

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

/2017 оны жилийн эцэс/

2018 оны 01 дүгээр сарын 18

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

УИХ-ын 2016 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын 2017 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээг хяналтанд авч ажиллаж байна. Уг төлөвлөгөөний дагуу макро эдийн засгийн бодлогын хүрээнд 6 зорилтын 26 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байна.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2017 оны жилийн эцсийн биелэлт 88,4 хувьтай байна. Төлөвлөгдсөн арга хэмжээнээс 17 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 8 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 40 хувийн тус тус хэрэгжилттэй, тасарсан арга хэмжээ байхгүй.

Үндсэн чиглэлийн жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдуулан хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг нотлох баримтанд тулгуурлан журмын дагуу үнэлгээний оноог өгөв.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧООН
/Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам/

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар					Дундаж, %	
			100	70	40	0	/-/	Жил ийн эцэс	Хагас жил
НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах зорилгоор геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх	9	7	2				93,3	73,3
	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, Тавантолгойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг байгуулж, төслийн үйл ажиллагааг эхлүүлэх	4	2	2				85,0	47,5
	“Алт-2” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг эхлүүлэх	3	3					100	100,0
	Ашиглахад бэлэн болсон уурхайн үйл ажиллагааг эхлүүлэх, олборлолт, экспортыг нэмэгдүүлэх	1	1					100	70,0
	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	7	4	2	1			82,8	70,0
	Газрын тосны эрэл, хайгуул, олборлолтыг тогтвортой нэмэгдүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийг барих бэлтгэл ажлыг хангах	2		2				85,0	85,0
Нийт дундаж		26	17	8	1			88,4	72,3

Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах, геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх зорилтын 9 үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнтэй, зорилтот түвшиндээ хүрсэн, тайлант хугацаанд төлөвлөсөн ажлууд хийгдсэн байна.

Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, Тавантолгойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг байгуулж, төслийн үйл ажиллагааг эхлүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын явц удаашралтай байна. Ялангуяа Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар биелэлт ирүүлсэн хэдий ч бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан талаар тодорхой биелэлтгүй байна. Тавантолгойн ордыг иж бүрэн, оновчтой ашиглах төсөл боловсруулах зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн, хөрөнгө оруулалтын гэрээ хэлцлийг байгуулах зорилгоор яамны зүгээс

шалтгаалах арга хэмжээг авсан, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй ч тодорхой үр дүн гарч эхэлсэн гэж үзлээ.

Монгол улсын Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг жилийн эцсийн байдлаар 88,4 хувьтай дүгнэлээ.

Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж.

Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, газрын тосны эрэл, хайгуул, олборлолтыг тогтвортой нэмэгдүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийг барих бэлтгэл ажлыг хангах зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд тайлант хугацааны зорилтот түвшиндээ хүрээгүй байгааг анхаарч цаашид ажлыг эрчимжүүлэх.

Цаашид бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд өгөх дүгнэлт, зөвлөмжийг баримт, нотолгоонд үндэслэн гаргах тул бодлогын газрууд биелэлтийн чанар, үнэн бодит байдалд анхаарах.

Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг бодитой тодорхойлох, яамны түвшинд хийгдэх ажлыг тодорхой төлөвлөх тал дээр бодлогын газрууд анхаарч ажиллах нь зүйтэй.

Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтэд хийсэн үнэлгээний тайланг хавсаргав.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2018/01/18